



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 364

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин
зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.2, 4.4, 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Боловсролын үнэлгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болсон 23,818,425.00 (хорин гурван сая найман зуун арван найман мянга дөрвөн зуун хорин таван) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг 2019 оны 01 дүгээр сарын 07, 07 дугаар сарын 17-ны өдрийн хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй тул дуудлагын худалдааг дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Боловсролын үнэлгээний төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ж.Ган-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР

0000708

эмчийн бодлого, зорилуу
2019 оны 09 дугаар сар
26/дугаар тогтоолын хамт

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/а шиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	/төгрөгөөр/				ТӨБЗГ-ын 2019 оны 205 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ	Худалдах доод үнийн санал
				Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг			
1	Санта-Фэ, УБИ 41-38, суудлын, арал: КМНСН81DP7U164772	2007/2011	14,320	23,818,425.00	23,818,425.00	-		3,500,000.00	2,100,000.00
	Нийт дүн			23,818,425.00	23,818,425.00	-		-	2,100,000.00
				(хорин гурван сая найман зуун арван найман мянга дөрвөн зуун хорин таван)				(гурван сая таван зуун мянган)	(хоёр сая нэг зуун мянган)

Нийт дүн